

## БУДДЫН ГҮН УХААНД СЭТГЭЛИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ

Н.Мөнхцэцэг (Докторант)

С.Янжинсүрэн (Доктор Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим, МУИС

**Түлхүүр үгс:** Лориг, Сэтгэл, Сүнс, Оюун ухаан, Ухамсар, Душа, Mind

**Товч утга:** Сэтгэлийг Философид өргөн судалж ирсэн бөгөөд олон сэтгэгч түүнийг тодорхойлохыг оролдож хүний амьдралд сэтгэл ямар үүрэгтэй болох, сэтгэл олон хувилбартай байж болох эсэх гэх зэрэгээр авч үзсэн байна.

Буддын философийн үндсэн асуудлуудын гол нь “сэтгэл” бөгөөд хүн, хүний амьдрал сэтгэлээс хамааралтай гэж үзэх ба энэхүү өгүүлэлд сэтгэл хэмээх ойлголтыг буддын философид хэрхэн авч үздэг хийгээд түүний мөн чанарыг хэрхэн тодорхойлдогийг тоймлохыг оролдов.

Нэг. Буддизм сэтгэл хэмээх ойлголтыг буддын гүн ухааны чойрын таван боть, ялангуяа учир шалтгааны ухааны эх сурвалжууд, тухайлбал, Шалгадгийн тийн тайлбар (*rnam grel tsaba*) зэрэг болон дөрвөн тогтсон таалалын ёсноо уламжлагдан ирсэн Оюуны эцсийн шинжлэл (*bLo rig*), чойрын бэлтгэл сургалтын эх сурвалж Сэтгэл, сэтгэлээс гарсны тийн агуулга (*Sems dang sems byun gi rnam gzhaḡ*) тэргүүтэй бусад сурвалж зохиолиуд, тэдгээрийн тайлбарт (*grel pa*) боловсрон хөгжжээ.

Сэтгэлийг санскритаар читта (*citta*), төвөдөөр сэм (*sems*, *uid*), оросоор душа, англиар *mind*, грекээр *psychē* гэж тэмдэглэж хэрэглэдэг.

Сэтгэлийг монгол хэлний тайлбар тольд “элдвийг сэтгэх ухааны эрхтэн бөгөөд бодол, дур, хүсэл; санаа сэтгэл, бодол сэтгэл, дур сэтгэл, хүсэл сэтгэл” гэж тодорхойлсноос үзвэл сэтгэлийг тодорхойлоход амаргүй бөгөөд олон янз ажээ. Энд лавтай сэтгэл гэдэг эрхтэнээс олон үйлдэл гардаг гэж хэлж байна.

Санскрит хэлэнд сэтгэл буюу *citta*, сэтгэхүй буюу *manas*, мэдэхүй буюу *vijcāna* гурав нэгэн утгаар илэрнэ. Эдгээр үг тус бүрдээ сэтгэл гэдэг ойлголтын ерөнхий шинж чанарыг илэрхийлдэг. Заримдаа

оюун ухааны үйл ажиллагаа, үйлдлүүдийг гаргана” “гэхдээ бас хоорондоо ялгагдана” гэжээ. Пали-англи толь бичгүүдэд *citta*-г зүрх сэтгэл, бодол санааны онцгой үйл хөдлөл ба сэтгэлийн хөдөлгөөнийг түлхүү тэмдэглэдэг байна.

“Manas гэдэг нь ерөнхий бодож сэтгэх чадварыг илэрхийлдэг”<sup>2</sup>. “Сэтгэхүй нь хөөрлийн процесстой холбоотой. Яагаад гэвэл сэтгэцийн үйл ажиллагаа нь хүсэл зоригуу илэрхийлэх нэг нөхцөл болж байдаг. Хүсэл нь бие, хэл болон сэтгэлээр үйлдэгдэнэ”<sup>3</sup> гэжээ. Энэ нь зургаан мэдрэхүй дээр суурилж олж авсан ойлголтуудын үр дүнг системчилж, юмс үзэгдлийг зааглан ялгаж, эцэст нь логик үйлдлүүдийн үндсэн дээр тухайн мэдлэгээ баталдаг байна. Иймээс *manas* нь оюун ухааны сэтгэхүйн талыг илэрхийлдэг байна.

*Vijcāna* гэдэг нь ухамсар юм. “Аливаа нэгэн ёс зүйн төлөв байдлыг ухамсарлах гэсэн утгыг илэрхийлнэ”<sup>4</sup>. Юмс үзэгдлийн хуурмаг байдлаас урган бий болдог аж. Ухамсраа нэг талаас туйлын байдалтай адилтгана. Нөгөө талаас нэгдмэл үндэстэй

<sup>2</sup> Sue Hamilton, Identity and Experience. LUZAC Oriental, 1996, 105-106

<sup>3</sup> I bid.,

<sup>4</sup> -Sue Hamilton, Identity and Experience. LUZAC Oriental, 1996, page 107

<sup>5</sup> - I bid, 108

<sup>6</sup> - I bid, page109

<sup>1</sup> Цэвэл, Я. Монгол хэлний тайлбар толь. УБ: 1966, 506

чухал оршихуйн илрэл гэж үзнэ.

Энэхүү гурван илрэл буюу ухамсрын энэ гурван хэлбэрийг ерөнхийд нь бодол санаа, оюун ухаан сэтгэхүй, өөрийн ухамсар хэмээн тодорхойлж болох бөгөөд хүний сэтгэцийн үйл ажиллагааны үе шат гэж ойлгож болох юм.

Төвдөөр сэтгэлийг *sems* гэх бөгөөд “сэтгэлийн билиг чанар нь өөрийн олон нөхөд болох сэтгэлээс гарсан тийн ухагч тэр мөний тул”<sup>7</sup> хэмээсэн нь гол сэтгэлтэй нэгэн зэрэг юмс үзэгдлийг ялган зааглаж сэтгэлээс гарсан хэмээгч олон бодлууд зэрэг төрдөг гэсэн үг юм.

Сэтгэлээс гарсан бодлуудтай нийлж танин мэдэхүйн үйл ажиллагаа явагддаг учир ухагч гэжээ. Гэхдээ төвөд эх сурвалжид сэтгэл гэдэг нь *citta* буюу хураагч гэсэн утгатай гэжээ. “Сайн болон муу завсрын үйлүүдийг сэтгэл дээр авьяас болгож хураадаг”<sup>8</sup> гэсэн нь хүнд оюуны үйл ажиллагаа тасралтгүй явагдаж, ямар нэгэн дадлага туршлагыг бий болгож байдаг гэсэн хэрэг юм. Иймээс сэтгэлээ ажаарах буюу түүний мөн чанарыг таньж мэдээд сэтгэлийг сайн тал руу нь чиглүүлж хөгжүүлэх нь чухалтай гэж буддизмд үзнэ.

Орос хэлний душа нь “Сэтгэл нь мөнхийн субстанции, материаллаг бус оршихуй, бурхан тэнгэрийн илэрхийлэл, сэрэл, мэдрэхүй, ухамсар, сэтгэлгээ, чадвар, болон урам зориг түүний амьдралын эхлэл шалтгааныг бий болгогч”<sup>9</sup> гэж тодорхойлоод сэтгэл бол тасралтгүй мөнх оршиж байдаг, тэнгэрлэг буюу тайлбарлашгүй үнэлэмж, оюун ухааны эх булаг гэж үзжээ.

Англи хэлэн дэх *mind*-ийг “барууны уламжлалаар сэтгэл гэдэг нь хүлээж авах, санах, үнэлэх болон шийдвэрлэхэд оролцдог оюуны цогц багтаамжийг илэрхийлсэн ойлголт юм”<sup>10</sup> гэжээ.

Сэтгэл бол тусгал байдлаар илэрдэг. Тухайлбал мэдрэмж, сэтгэлийн бодит байдал юм. “Сэтгэлийг ойлгоё гэвэл түүний метафизик мөн чанарыг нь ойлгох

хэрэгтэй”<sup>11</sup> гэж үзсэн нь дотоод мэдрэмж гэхээсээ илүүтэй аливааг ухамсарлахуйг түлхүү илэрхийлсэн байна.

Грек хэлний *psychē*-ийг тайлбар толиноо “Зүрхний үйл ажиллагааг тодорхойлох арга юм”<sup>12</sup> гэжээ. Энэ нь нэг талаас хүний биеийн гол эрхтэнтэй холбоотой бөгөөд түүний үйл ажиллагааны төлөв байдлыг илэрхийлдэг гэж хэлж гэж ойлгож байна.

Ер нь “*Psychē*”-ийг шинжлэх ухаанд янз бүрийн утгаар хэрэглэж ирсэн бөгөөд үүнд сүнс, сэтгэл, сэтгэц орно.

Дээрх тодорхойлолтуудаас үзвэл сэтгэл хэмээх нь тасралтгүй үргэлжилдэг мөнхийн оршихуй төдийгүй хүний оюун ухаан, дотоод зөн мэдрэмжийг илэрхийлдэг бөгөөд олон талтай, нарийн нийлмэл ойлголт болох нь харагдаж байгаа юм.

Монголчуудын хувьд сэтгэлийн тухай эртнээс авч үзэж иржээ. Энэ тухай “овгийн байгууллын үе буюу 5000-7000 жилийн тэртээгээс МЭӨ III зуун хүртэлх үеийн бөөгийн шүтлэгтэй холбож үзэх нь”<sup>13</sup> зайлшгүй юм. Энэ үеэс монголчууд сэтгэл, сүнсний тухай мэдлэгийг хуримтлуулжээ. Тийм ч учраас амьдрал ахуйд хэрэглэгддэг сэтгэлтэй холбоотой үгс олон байна. Тухайлбал, “Сэтгэлийг ариусгахуй” номонд “Аугаа сэтгэл, айх сэтгэл, амраг сэтгэл, ариун сэтгэл, ачлалт сэтгэл, атхаг сэтгэл, атаат сэтгэл, бадрангуй сэтгэл, барьцахуй сэтгэл, басамжлах сэтгэл, бат сэтгэл, бахдах сэтгэл, баясгалант сэтгэл, бодлогогүй сэтгэл, бодь сэтгэл, дотоод сэтгэл, журамт сэтгэл, завсаргүй сэтгэл, зөв сэтгэл, зохистой сэтгэл, зөөлөн сэтгэл, нинжин сэтгэл, нигүүлсэнгүй сэтгэл, нэгэн үзүүрт сэтгэл, омогт сэтгэл, оргилуун сэтгэл, өрөвдөх сэтгэл, сэтгэл сэтгэл татам, сэтгэл тогтох, сэтгэл төгөлдөр, сэтгэл төрүүлэх, сэтгэл түвшин, сэтгэл тэнүүн, сэтгэл уужрах, сэтгэл уярах, сэтгэл үүсгэх, сэтгэл үхэх, сэтгэл хайлах”<sup>14</sup> гэх мэтээр гаргасан нь сэтгэл хэмээх ухагдахуун ямар өргөн олон тал, илрэлтэй, хүний оршихуйн чухал ухагдахуун болох нь эндээс харагдаж байна.

<sup>7</sup> - Сэтгэл хийгээд сэтгэлээс болсны тийн агуулга (Төвд хэлээр), /dbal mang paṇḍita dkon mchog rgyal mtshan, *sems dang sems byun gi nam gzhaḡ*/ Энэтхэг, Брайбүн Гоман дацан: 2007, 1

<sup>8</sup> - Сэтгэл хийгээд сэтгэлээс болсны тийн агуулга (Төвд хэлээр), /dbal mang paṇḍita dkon mchog rgyal mtshan, *sems dang sems byun gi nam gzhaḡ*/ Энэтхэг, Брайбүн Гоман дацан: 2007, 11

<sup>9</sup> ushakovdictionary.ru,

<sup>10</sup> www.britanica.com

<sup>11</sup> www.britanica.com

<sup>12</sup> enc-dic.com>philosophy/ psihika

<sup>13</sup> О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, УБ, 2014, 27 дахь тал

<sup>14</sup> -Ш.Чоймаа, С.Янжинсүрэн, Сэтгэлийг ариусгахуй. УБ: 2007, 85 дахь тал

Буддын гүн ухааны үүднээс “Сэтгэл” хэмээх ухагдахууныг тодруулахын тулд түүнийг агуулагч хүний тухай хэрхэн авч үздэгийг товч дурдая. Хүний бүтэц бүрэлдэхүүнийг цогцын үүднээс дүрс, мэдэл, төгөлдөр бус хуран үйлдэхүйн харьцаа гээд хүний гол шинж танин мэдэж гэгээрэхүйн чанарт оршино гэж үздэг.

Бодгалыг<sup>15</sup> судраас “Алимад дүрс хийгээд сэтгэл ба сэтгэлээс болсны ахуй нэрийтгэсэн бүлгээ. Мөнхүү түүнээс бусдад үл нэрийдмой<sup>16</sup>” гэсэн нь дүрс гэдэг бол бие, сэтгэл хийгээд сэтгэлээс болсон хэмээх мэдэл, оюун гэж үзжээ. Энэ нь бодгалыг (санс: *pudgala*, тө: *gang zag*) зөвхөн нөхцөл шалтгааны эрхээр бүтэж бий болсон мөнх бус, нэрийтгэгдсэн амьтан гэж үзсэн хэрэг юм. Хүний үүслийг гариг эрхэсийн болгож төрөхөөс үхэх хүртэл шүтэлцэхүйн жамаар өөрөө өөрийгөө гэгээрүүлэх мөрийн орчил, байгаль ертөнцийн зүй тогтолтой холбон шалтгаан үр, барилдлагын хэлхээс үндсийг туулагч гэж үздэг байна.

Сэтгэлийг дээр дурдсан төвөд эх сурвалжид тулгуурлаж “сэтгэл” /*sems, mind*/ ба сэтгэлээс болсон /*sems buyng, mental function*/ хэмээх ойлголтуудын хүрээнд авч үзвэл: Сэтгэлийг “Өөрийн орон болох утгын мөн чанарыг өөрийн хүчээр мэдэх талаас нь агуулсан сэтгэл тэр гол сэтгэлийн бэлгэ чанар болой<sup>17</sup>” гээд “сэтгэл /*sems, mind*/, ухамсар (мэдрэхүй) /*yed, conscioussness*/, тийн мэдэл /*gnam par shes pa*/, гол сэтгэл /*mind factor*/ гэх нь адил гэжээ. Энэ нь өөрийн орны шинж чанарыг таних нь гол сэтгэл болох ажээ. Орныг мэдэж таниж байгаагаар ухамсар (мэдрэхүй) гээд, орныг тус тусад нь ялгаж сайтар мэддэгээр нь тийн мэдэл гэж тус тус тодорхойлжээ.

Үүнийг таван цогцод / *pacsa skandha, phun po lnga, the five aggregates*/ хуваадаг. Таван цогцын эхнийх нь дүрс /*gūpa skandha, gsugs kyi, aggregate of form*/. Үүнд дөрвөн махбодь: шороо, ус, гал, хий багтана.

Түүнчлэн уг дөрвөн махбодиос гаралтай чухал авагдахуун дүрсүүд буюу

нүд, чих, хамар, хэл, бие орох бөгөөд гадаад ертөнц дэхь тэдгээрийн оногдохуун буюу таван вишай: дүрс, дуу, үнэр, амт, хүрэлцэхүй хийгээд сэтгэхүйд орох үзэл, бодрол ойлголтууд мөн багтана. Иймээс буддын философи дахь дүрс хэмээх ойлголтод материйн гадаад дотоод шинж хоёулаа хамаатай байна.

Хоёр дахь нь сэрэхүйн цогц /*vedanā skandha, tshor bi phun po, aggregate of peeling*/. Үүнд бие болон сэтгэхүйн эрхтнээр дамжин гадаад ертөнцтэй холбогдсоноор үүсэх тааламжтай тааламжгүй, саармаг зэрэг бидний бүх сэрэл хүртэхүй багтана. Тэдгээр нь зургаан янз байна. Өөрөөр хэлбэл бидний бие сэтгэлийн бүхий л мэдрэхүй энд багтана.

Энд сэтгэхүй хэмээх ойлголт хамаарагдана. Сэтгэхүй нь нүд чих лүгээ адил чадвар буюу эрхтэн юм. Түүнийг аливаа нэгэн чадварын адилаар анзаарч хөгжүүлж болох юм. Нүд, сэтгэхүй хоёрын ялгаа гэвэл нүд нь өнгө мэдэрч байхад, сэтгэхүй нь үзэл бодол, оюун санааны оногдохуйг мэдэрнэ.

Бид ертөнцийн үзэгдлийг өөр өөрөөр хүлээж авдаг. Гэтэл энэ нь ертөнцийн зөвхөн нэг л хэсэг, нэг л агшныг илэрхийлэхээс биш, бүхэл бүтнээр нь цогцоор нь илэрхийлж чадахгүй юм.

Сэтгэхүй бол эдгээр (таван эрхтэнд өртөж буй ертөнцөөс) бие махбодын үйлдлээс хамаарч түүгээр нөхцөлдөж байдаг. Ертөнцийн хэсэг болох үзэл бодрол нь биет үйлдлээр үүсэж нөхцөлдөж байдаг учраас түүнийг сэтгэхүйгээр хүлээж авна. Иймээс сэтгэхүйг нүд чихний нэгэн адил сэрлийн чадвар буюу эрхтэн гэж үзнэ.

Гурав дахь нь хуран мэдэхүйн цогц /*samjca skandha, 'dushes kyi phun po, aggregate of perception*/. Сэрэхүйн нэгэн адил зургаан төрөл бөгөөд энэ нь дотоод зургаан чадвартай холбоотой, гадаад зургаан оногдохуунд зохицсон байдаг. Хуран мэдэхүй нь биеийн буюу сэтгэлийн оногдохуун /вишай, *yul*/ аль алиныг хүлээн авч чадна.

Дөрөв дэх нь хуран үйлдэхүйн цогц /*samskāra skandha, 'du byed kyi phun po, aggregate of compositional factors*/. Энэ цогцод хуран үйдсэн бүхий л сайн муу үйл

<sup>15</sup> Бодгалыг (санс: *pudgala*, тө: *gang zag*) гэнэ. Бодгаль буюу хүн нь гадаад хүчин зүйлийн үрээр буй болсон бие сэтгэлийн нийлбэр юм.

<sup>16</sup> Төвд-Хятад дотоод ухааны үгсийн сан (төвд, хятад хэлээр), /*bod rgya nang don rigba'i tshig mdzod*/ (I боть) Хөх нуур: 1992, 179

<sup>17</sup> -Т.Булган, Буддын философийн дэвтэр. УБ: 2010, 34

(karma) багтана. Хуран үйлдэхүй нь сэрэхүй хийгээд хуран мэдэхүйн нэгэн адил зургаан янз байна. Тэдгээр нь дотоод зургаан чадвартай холбогдож гадаад ертөнцийн (бие-сэтгэлийн) оногдохуунтай уялдана. Гагцхүү хуран хуран үйлдэхүй бус тэдгээр нь үйлийн үрийг төрүүлэхгүй.

Дуршил, хүсэл, сүсэг, бишрэл, самади, билиг, хичээнгүй, мунхаг, тачаангуй, хөнөөхүй, омог, найдангуй зэрэг үйлдэл нь үйлийн үрийг бүтээж чадна.

Хуран үйлдэхүйн цогцыг бүрдүүлдэг сэтгэлийн олон үйлдэлүүд бий. Үүнийг сэтгэлээс болсон /sems buyng, mental function/ буюу нөхөр сэтгэл гэж нэрлэдэг. Энд дотоодын дөрвөн тогтсон тааллын ёсноос Вайбхашика нар 46 сэтгэлээс болсныг тоолдог бол Йогачера нар 51 сэтгэлээс болсон буюу сэтгэхүйг ялгадаг байна.

Сурвалжаас “Өөрөө нөхөр болон одох орны сэтгэл байдаг, бусдыг ухахын мэдэл тэр мөний тул<sup>18</sup>” гэсэн аж. Өөрөөр хэлбэл аливаа зүйлийн мөн чанарыг таниж мэдэхээ сэтгэл, харин утгын ялгааг таньж мэдэхээ сэтгэлээс болсон (сэтгэхүй) гэж үзсэн ажээ. Ангилбал: Хотолд одох тав, Орноо магадлагч тав, Буяны арван нэг, Язгуурын зургаан нисваанис, Ойрын хорин нисваанис, Бусдад урвах дөрөв гэж ангилж үздэг байна.

Тав дахь нь тийн мэдэхүйн цогц /vijñacā skandha, nam par shes kyi phun po, aggregate of consciousness/. Энэ нь зургаан эрхтний аль нэгийг суурь болгож гадаад зохих зургаан үзэгдлийн (дүрс, дуу, үнэр, амт, хүрэлцэхүй хийгээд сэтгэхүйн вишай) аль нэгийг оногдохуй болгосон сөрөг үйлдэл буюу хариу тусгал юм.

Жишээлэхэд үзэхүй танин мэдэхүй нь нүдийг суурь болгож, үзэгдэх дүрсийг оногдохуун болгоно. Сэтгэхүйн танин мэдэхүй нь сэтгэхүйг суурь болгож, үзэл бодлыг оногдохуун болгодог.

Тиймээс тийн мэдэхүй нь бусад эрхтэн чадваруудтай холбогдож үүснэ. Энэ нь сэрэхүй, хуран мэдэхүй, хуран үйлдэхүйн нэгэн адил зургаан төрөл байх бөгөөд мөн л

дотоод зургаан эрхтэнтэй холбогдож гадаад зургаан оногдохуунтай уялдсан байна.

Тийн мэдэхүй нь оногдохууныг үл ялгаруулна. Энэ бол ухамсрын нэг төрөл оногдохуун аяндаа байгааг л ухаарах ухамсар юм.

Тийн мэдэхүйг ямар нөхцөлөөс болж үүссэнээр нь:

Нүдний тийн мэдэхүй (chasur vijcāna, miggi nam par shes pa, eye consciousness)

Чихний тийн мэдэхүй (śrotra vijcāna, rna ba'i nam par shes pa, ear consciousness)

Хамрын тийн мэдэхүй (Ghrana vijcāna, sna 'i nam par shes pa, nose consciousness)

Хэлний тийн мэдэхүй (jihva vijcāna, ice'i nam par shes pa, tongue consciousness)

Биеийн тийн мэдэхүй (kāya vijcāna, lus kyi nam par shes pa, body consciousness)

Сэтгэлийн тийн мэдэхүй (mano vijcāna, yed kyi nam par shes pa, mental consciousness) гэж тус тус нэрлэдэг байна.

Эдгээрийг тодорхойлохдоо “Өөрийн нийт бусын эзэн шалтгаанд шүтэж гарсан, өөрийн орон болсон дүрс төрөн түгэхүйн мөн чанарыг өөрийн хүчээр үзэх тэр мэдрэхүй нь тийн мэдлийн бэлгэ чанар болой” гэж тодорхойлсон нь объектын байдлыг эрхтэн тус бүрийн тусламжтайгаар (өнгийг ялгаж байгаа нүдний мэдрэхүй, дуу авиаг сонсож байгаа дууны мэдэл, үнэрийг үнэртэх хамрын мэдэл, амт амтлах мэдэл, хатуу, зөөлнийг мэдрэх хүртэхүйн мэдэл, мөнх бусыг мэдэх дотоод сэтгэл) тус тусад нь ялгаж танихыг сэтгэлээс болсон гэж үзжээ. Ийнхүү бид танин мэдэхүйн 6 суваг (эрхтэнээр мэдэх тав ба зургаа дахь нь сэтгэлийн тийн мэдэл)-аар дамжуулан юмсыг хүлээж авдаг. Сэтгэлийн тийн мэдэлд бодох чадвар, зөн билгээр мэдэх зэрэг багтана байна. Сэтгэлийн тийн мэдэл нь биеийн амгалангийн тухай бодож байдаг бөгөөд биеийн дээд амгаланг олох хийгээд хамгийн бага зовлонтой байхад чиглэгдсэн зан байдлыг санаачлан бий болгодог. Ийнхүү сэтгэлийг тодорхойлж, гарган тавьж, ангилан ялгаж байгаа нь түүний мөн чанарыг нь танин мэдэхийн тулд юм.

Сэтгэлийн мөн чанар нь гэгээн гэрэл шиг тунгалаг бөгөөд хайрлах энэрэх

18 - Сэтгэл хийгээд сэтгэлээс болсны тийн агуулга (Төвд хэлээр), /dbal mang paṇḍita dkon mchog rgyal mtshan, sems dang sems byun gi nam gzahag/ Энэтхэг, Брайбүн Гоман дацан: 2007, 11

зэрэг олон үйлдэлтэй байдаг ч дотоод (нисваанис) болон гадаад (орчин) хүчин зүйлсийн нөлөөгөөр байнгын хувирч өөрчлөгдөж хөдөлгөөнд орших ба улмаар сэтгэлийн сөрөг үзэгдлүүдээс шалтгаалан хиртдэг бөгөөд түүнийг нисванист сэтгэл, нүгэлт сэтгэл, хирт сэтгэл, муу сэтгэл, буртагт сэтгэл зэрэг олон янзаар нэрлэнэ. Тиймээс нисванисаас сангид байх, нэгэнт холбогдсон бол нисванисыг арилгахын тулд энэрэн нигүүлсэхүй сэтгэлийг үүсгэн дадуулах, танин мэдэх чадвар, оюун ухаанаа хөгжүүлэх, билгүүнийг төрүүлэх хэрэгтэй хэмээнэ.

Сэтгэл нь тухайн нэг зүйлийн тухай мэддэг, мөн тухайн зүйлийг сэтгэл өөрөө хэрхэн хүлээн авч мэдэрч байгаагаа мэдэрч байдаг гэвэл сэтгэл хэмээх ойлголт нь аливаа оршихуйн үүтгэлийг танин мэдэх гол үүд бөгөөд хүн өөрийн сэтгэл, оюуны аливаа үйл, түүнээс гарах үр дагаврыг (амгалан хийгээд зовлон) ухааран сэтгэлийнхээ муу чанаруудыг боомилж, сайн чанаруудыг тогтоох аргазүйг буй болгохыг эрмэлздэгээрээ буддын философийн үнэ цэнэ оршино.

Сэтгэл нь нисваанистай үргэлж холбогдох бөгөөд тэр нь ухамсрын дотоодод намжмал байж (ухамсарлагдаагүй байж) цаг, нөхцөл шалтгааны эрхээр илэрч байдаг. Өөрөөр хэлбэл сэтгэлд тогтсон нисваанисыг хориогүйгээс арвижиж, олон зүйлийн муу үйлийг үйлдэх шалтгаан болдог гэнэ. Тиймээс сөрөг, нисваанист сэтгэлтэй үл нөхцөн сэтгэлийн өөрийнх нь язгуур мөн чанар болох тунгалаг мөн чанарыг бясалган хөгжүүлэх хэрэгтэй гэж үздэг.

Орчин үед хүний хөгжлийн асуудлыг бие сэтгэлийн харилцаанд нь авч үзэх хандлага эрчимжиж, сэтгэл судлал, квантын физик зэрэг шинжлэх ухааны салбарууд буддизм руу хандах болсноор сэтгэл судлалын шинэ чиглэл хандлагууд бий болж байгаагаар тайлбарлаж болох юм. Тэрчлэн төвлөрийн эсвэл бясалгалын шинжлэх ухаан (contemplative science) гэж бичиж ярих болсон байна. Ялангуяа анагаах ухаан энэ чиглэл дээр төвлөрөх хандлага ажиглагдаж байна.

Буддын уламжлалт анагаах ухаанд “хүн биеийн амин судал буюу амьсгал, цөс, тунгалаг гурав дээр суурилсан байдаг.

амьсгал, цөс, тунгалагын доголдол нь “гурван хор” буюу оюун санааны гурван эмгэг болох шунал, уур, мунхаг ( нэгэн зүйл сэтгэлүүд) гурваас үүсдэг гэж үздэгээс харвал буддизмд хүний аливаа энэлгээт асуудлыг сэтгэлтэй холбож үздэг болох нь тодорхой байгаа юм.

Сэтгэлээ хэрхэн боловсруулж төлөвшүүлснээр нь хүнийг бүхэлд нь тодорхойлдог нь буддын сэтгэлийг үзэх үзлийн онцлог мөн болно.

## НОМ ЗҮЙ

1. Оюун ухааны эцсийн шинжлэл, гайхамшигт номлолын үзэсгэлэнт алтан эрхи хэмээгдэх оршвой. (Төвд хэлээр), / blo rig gi nam gzhas nyung gsal legs bshad gser gyi pheng mdzes zhes bya ba bzhugs so/ Энэтхэг, Брайбүн Гоман дацангын номын сан: 1999
2. Ш.Чоймаа, С.Янжинсүрэн, Сэтгэлийг ариусгахуй. УБ, 2007
3. Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй. (Орч: С.Гантөмөр) Боть 5. УБ, 2005
4. Сэтгэл хийгээд сэтгэлээс болсны тийн агуулга (Төвд хэлээр), /dbal mang pa□□ita dkon mchog rgyal mtshan, sems dang sems byun gi nam gzhas/ Энэтхэг, Брайбүн Гоман дацан, 2007
5. Васубандху. Абхидхармакоша энциклопедия. (biblioteca buddhica-XXXV) Москва, 1990
6. Т.Булган. Бодичаравтара-Буддын гүн ухааны арга билгийн цогц бүтээл болох нь: (Эрдэм шинжилгээний бичиг) УБ, 1999
7. Уданаварга ба Дармапада хоёрыг хавсарч судалсан шаштир. УБ, 1966
8. О.Чимэг, Зонховын Бодь мөрийн зэрэг дэхь нийгэм философийн үзэл санаа, УБ, 2001
9. Бурхан, Номын Ишийн Даяг, (sangs rgyas chos gzhas gi tshig mdzod) :1992
10. Ф.И.Щербатской, Теория познания и логика по учению позднейших буддистов. СПб, 1909
11. М.Гантуяа, Буддын билэг барамидын

философи үзэл, УБ, 1994

12. Т.Булган, Буддын философийн дэвтэр, УБ, 2010
13. “Найман мянгат” нэрт их хөлгөн судар.
14. Монголын эрдэмт лам нарын төвд хэлээр туурвисан зохиол бүтээлийн ном зүй, Үндэсний номын сан (I боть), УБ, 2013
15. Мудрость тысячелетий энциклопедия, (автор-сост Балязин, В) Москва: 2012
16. Төвд-Хятад дотоод ухааны үгсийн сан / bod rgya nang don rigb/, I- II боть, Хөх нуур, 1992

### **ABSTRACT**

Mankind mind has been trying to recognize the nature of Soul two millennium ago. The western psychology was based on different theoretical and methodological trends, which have been examined the soul in a particular aspects. Contrary, Buddhism defines soul on the basis of precise complex classification and developed a comprehensive theory and methodology for improvement. The value of Buddhist philosophy consists in fact that it has developed methodology, when the man tried to understand each own action / peace and suffering/, seeking to limit bad consequences and to emphasize high qualities. Indeed, its impact and scope is expanded. The article makes review of category of soul in Buddhist philosophy and its interpretation.